

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр
сарын 07 -ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн болно.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Б.Бат-Эрдэнэ нар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нараас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Үндсэн чиглэлд хийсэн аудитын дүгнэлтээр Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн зорилт, арга хэмжээнээс Ногоон хөгжлийн асуудал бүрэн хэрэгжээгүй байгааг анхаарах, үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй бол холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарт төлөвлөсөн арга хэмжээний биелэлт хангалтгүй байна, гадаргын усны усыг хуримтлуулах, Хэрлэн голын эхийг хамгаалах асуудалд анхаарах, Хүнс, хөдөө аж ахуйн яам малын тоо өсөж байгаатай холбогдуулан тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх асуудал дээр анхаарч, малын тэжээл үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх замаар дэмжлэг үзүүлэх,

Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва цас, борооны усыг хуримтлуулах, аюултай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх, бэлчээр хамгаалах, оготно устгах ажлыг улсын хэмжээнд авиахимийн аргаар устгах аргыг сэргээх, Хүнсний аюулгүй байдлын тухай болон Хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд анхаарах,

Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан өмнөх Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байсан арга хэмжээг үргэлжлүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх асуудлыг анхаарах,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эргэн харах, урамшуулал авсан болон гурилын үйлдвэрт тушаасан будааны хэмжээ зөрүүтэй байгааг анхаарах,

Улсын Их Хурлын гишүүн С.Батболд байгаль орчны чиглэлийн арга хэмжээний биелэлт хангалтгүй хэрэгжсэн, үүнээс 4 нь 70-с доош хувьтай, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нэн ховор, ховордсон амьтдын эрсдэлийн үнэлгээ хийх, устах аюулд орж байгаа ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, нэн


ховор, ховор ургамлыг тарималжуулах, генофондыг бий болгох ажлуудын хэрэгжилт муу байна, хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрмжийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийг дэмжих, био бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, жимс, жимсгэний төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 3 зорилт 50 хүрэхгүй хувьтай байгаа нь Хүнс, хөдөө аж ахуйн яам төслийг сонгон шалгаруулаад Хөгжлийн банкинд хүргүүлсэн боловч санхүүжилт нь хийгдээгүйтэй холбоотой байна, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газрыг хэвээр ажиллуулах, аудитын дүгнэлтээр үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил тодорхой үр дүнд хүрээгүй, үндсэн чиглэлд тусгагдсан томоохон зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөөгүй, өмнө гарсан Улсын Их Хурал, байнгын хорооны тогтоол, аудитын дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч нар ажилдаа тусгаагүй байна гэсэн дүгнэлтийг салбарын сайд нар анхаарах зэрэг саналуудыг хэлсэн болно.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхээр тогтлоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



С БАТБОЛД